



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ СУМ ДУНДЫН
АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙН
ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 308/ЗТ2026/00001

Сайншанд сум

Хэрэг нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах,
хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх
шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох
нарийвчилсан журам

Дорноговь аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнийг Ерөнхий шүүгч Ц.Ариунзул даргалж, шүүгч Д.Наранцэцэгийг оролцуулан Хэрэг нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журмыг тогтоох асуудлуудыг хэлэлцэв.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, 19 дүгээр зүйлийн 19.2.2, 19.2.5, 19.3.1, 19.3.2, 19.7, 19.8 дахь хэсэгт заасныг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1.Хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журмыг хавсралтаар баталсугай.

2.Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор тогтоосон дарааллаар шүүгчдийн нэрсийг нэгдсэн системд байршуулахыг мэдээлэл технологийн мэргэжилтэнд даалгасугай.

3.Нэгдсэн системд шүүгчдийн нэрсийг сугалааны дараалал болгох

1.Ц.Ариунзул

2.Б.Гончигсумлаа

3. Д.Наранцэцэг гэх дарааллаар байршуулж тойрог үүсгэх.

4. Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

5.Шүүгчдийн зөвлөгөөний тогтоолыг Дорноговь аймаг дахь Шүүхийн тамгын газарт хүргүүлж, нийтлэг журамд заасны дагуу хяналт тавьж ажиллахыг шүүхийн тамгын газрын дарга /С.Бурмаа/-д даалгасугай.

6.Уг тогтоол батлагдсантай холбогдуулан тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 308/ЗТ2025/00004 тоот тогтоолыг 2025 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн хүчингүйд тооцсугай.


7.Энэ тогтоол нь шүүгчдийн зөвлөгөөний дараагийн тогтоол гартал хүчин төгөлдөр мөрдөгдөхийг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Ц. АРИУНЗУЛ

ШҮҮГЧ

Д. НАРАНЦЭЦЭГ



**ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛ, ГОМДОЛ, ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ, ХУВААРИЛАХ
БОЛОН ХЭРЭГ, МАРГААНЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮГЧ, ШҮҮХ
БҮРЭЛДЭХҮҮНИЙГ СУГАЛААГААР ТОМИЛОХ НАРИЙВЧИЛСАН ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.1 “Хэрэг” гэж адил шатны шүүхээс шилжиж ирсэн хэрэг, харьяалал тогтоолгон ирсэн хэрэг, прокуророос шилжин ирсэн эрүүгийн болон зөрчлийн хэрэг, прокуророос сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих санал гаргасан хэрэг бүртгэлтийн болон эрүүгийн хэрэг, шүүгч, нийт шүүгчдээс татгалзаж ирсэн хэрэг, давж заалдах, хяналтын шатны шүүхэд хянауулахаар хүргүүлсэн хэрэг, дээд шатны шүүхээс шийдвэр нь хүчингүй болж дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн хэрэг, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг шүүх өөрөө хянаж хүчингүй болгон дахин шийдвэрлэх хэрэг, шинээр илэрсэн нөхцөл байдлаар хянаж, шийдвэр тогтоолыг хүчингүй болгон дахин шийдвэрлэх хэрэг, нэгтгэж, тусгаарласан хэрэг, мөн шүүгчийн бүрэн эрх нь дуусгавар болсон, эсхүл шүүгч удаан хугацаагаар эзгүй байгаа тохиолдолд бусад шүүгчдэд хуваарилах хэргийг ойлгоно.

1.2 “нэхэмжлэл” гэж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2-т заасан нэхэмжлэл, 12.1.3-т заасан гомдол, хүсэлт, 12.1.4-т заасан гомдлыг ойлгоно.

1.3.“өргөдөл, гомдол, хүсэлт” гэж Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 12.1.4-т заасан гомдол хүсэлт болон өөрт хуваарилагдсан хэргийг хянан шийдвэрлэх тухайн шүүгчийн бүрэн эрхэд шууд хамаарах хүсэлтээс бусад Эрүү, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гомдол, хүсэлт, арбитрын өргөдөл, прокурорын санал, дүгнэлтийг ойлгоно.

1.4.“тойрог дотор санамсаргүй тохиолдлыг аргаар” гэж тухайн тайлант оны шүүгчдийн зөвлөгөөнөөр сугалаа ашиглан тогтоосон шүүгчдийн нэрсийн дараалал бүхий тойрог дотроос санамсаргүй байдлаар сонгож хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хуваарилахыг ойлгоно.

1.5.“хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилахгүй байх нөхцөл” гэж шүүгчдийн зөвлөгөөнөөр тогтоосон шүүгч удаан хугацаагаар өвчтэй, чөлөөтэй байх, сургалтад хамрагдах зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар эзгүй (ажиллаагүй) байхыг ойлгоно.

1.6.“ээлжээр ажиллах шүүгч” гэж ажлын бус цагаар, долоо хоногийн амралтын өдөр болон нийтээр амрах баярын өдөр сэжигтнийг баривчлах асуудлыг шийдвэрлэхээр тухайн шүүхийн шүүгчийн зөвлөгөөнөөс тогтоосон хуваарийн дагуу томилогдсон шүүгчийг ойлгоно.

Хоёр. Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах

1.Нэгдсэн системд байрших тойрогт шүүгчдийн нэрсийн дарааллыг сугалаагаар сугалахад

1.Ерөнхий шүүгч Ц.Ариунзул

2.Шүүгч Б.Гончигсумлаа

3.Шүүгч Д.Наранцэцэг гэсэн дарааллаар эрүү, иргэний нэгдсэн системд байршуулахаар шийдвэрлэлээ.

Тухайн шүүхэд бүрэлдэхүүн хүрэлцэхгүй тохиолдолд адил шатны шүүхээс бүрэлдэхүүн авна.

2.Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах шийдвэрийг хуанлийн өдөр бүр шөнийн цагаас бусад цагт тасралтгүй хүлээж авах бөгөөд уг асуудлыг ажлын бус цагаар, долоо хоногийн амралтын өдөр болон нийтээр амрах баярын өдөр хүлээн авч, шийдвэрлэх ээлжээр ажиллах шүүгчийг одоо ажиллаж байгаа Д.Наранцэцэг шүүгч шийдвэрлэнэ.

3.Эрүүгийн хэргийн хувьд шүүх бүрэлдэхүүнийг эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системээс хуваарилагдсан бүрэлдэхүүнээр шийдвэрлэнэ.

4.Адил шатны өөр шүүхийн шүүх бүрэлдэхүүнд томилолтоор ажиллах шүүгчийг энэ журмын 2.1-д заасан дарааллаар томилно. Томилолтоор ажиллах шүүгч шүүх хуралдаан давхцсан, өвчтэй, чөлөөтэй, сургалтанд хамрагдсан, ээлжийн амралттай тохиолдолд дараагийн шүүгчийг томилно.

5.Шүүгч өөрт хуваарилагдсан эрүү, иргэн, зөрчлийн хэрэгт захирамж, тогтоол, шийтгэвэр, шийдвэр, шийтгэх тогтоолын биелэлтийг хангах зорилгоор болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан бусад хүсэлтүүдэд хариу өгөх зорилгоор албан бичгийг, Ерөнхий шүүгч Давж заалдах, Хяналтын шатны шүүх болон өөр шүүхэд хэрэг шилжүүлсэн тохиолдолд болон шүүхийг төлөөлж байгаа аливаа асуудалд албан бичиг гаргана.

6.Шүүхийн тамгын газрын мэдээлэл лавлагааны мэргэжилтэн шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол хүсэлтийг хүлээн авсан даруйд нэгдсэн системд оруулан хуваарилалт хийж, дардас даран хүлээн авсан бүртгэлийн дэвтэрт цаг, минутын дарааллаар бүртгэн хуваарилагдсан шүүгчид, хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүгчид хүлээлгэн өгөх боломжгүй бол шүүгчийн туслахад гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

7. Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн томилох үйлдэл бүрийг дүрс бичлэг хийж 7 хоног бүр хадгалах төхөөрөмжид хуулбарлан хадгалах ба түүнд шүүхийн тамгын газрын дарга тогтмол хяналт тавьж ажиллана.

8.Шүүхийн тамгын газрын Мэдээлэл лавлагааны мэргэжилтэн нэгдсэн системээр хуваарилагдсан хэрэг, өргөдөл, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээдийн хүсэлтээр хэвлэн өгч, өгсөн тохиолдолд энэ баримтыг хэрэгт хавсаргана.

8.Шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг нэгдсэн системээс урьдчилан мэдэх боломжгүй, тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар хуваарилахдаа:

Гурав. иргэний хэрэг хуваарилах

1.Нэхэмжлэл, адил шатны шүүхээс шилжиж ирсэн хэрэг, харьяалал тогтоож ирүүлсэн хэрэг, өргөдөл, адил шатны шүүхээс ирсэн иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлд заасан гомдол, эвлэрлийн гэрээ, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлд заасан улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт, нотариатын мэдэгдэх хуудас, арбитрын шийдвэрийг шүүхээр баталгаажуулах хүсэлт, ажиллаагүй байгаа бусад шүүгчийн шийдвэр албадан гүйцэтгүүлэх хүсэлт, өөр шүүхийн даалгаварыг тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар хуваарилна.

2.Хүлээн авахаас татгалзсан, буцаасан нэхэмжлэл, хэргийг хэрэгсэхгүй болсон тохиолдолд урьд хүлээн авсан шүүгчид системээс гараар хуваарилж энэ журамд зааснаар хүлээлгэн өгнө. Нэхэмжлэлийг дахин хуваарилахад тухайн нэхэмжлэл тойрогт орохгүй.

3.Давж заалдах болон хяналтын шатны шүүхээс шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин шийдвэрлүүлэхээр буцаасан хэргийг шийдсэн шүүгчийг оруулахгүйгээр тойрог дотор санамсаргүй аргаар хуваарилж шийдвэрлэнэ.

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлд зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас шүүгчийг татгалзан гаргасан хэргийг тухайн шүүгчийг оролцуулахгүйгээр сугалаагаар бусад шүүгчид хуваарилна.

5.Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн хэрэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74, 106 дугаар зүйлд зааснаар гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг мөн хуулийн 124 дүгээр зүйлд зааснаар хүчингүй болгосон тохиолдолд уг хэргийг өмнө шийдвэрлэсэн тухайн шүүгчид хуваарилна. Тухайн шүүгч тус шүүхэд ажиллахгүй болсон тохиолдолд системээс тойрог дотор санамсаргүй аргаар шүүгчид хуваарилна.

6.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 68.3-д заасан үндэслэлээр хэргийг нэгтгэхдээ нэхэмжлэлийг шүүхэд хүлээн авсан он, сар, өдөр, дугаараар эхэнд хүлээн авсан хэрэгт нэгтгэж, эхэнд хүлээн авсан хэргийг шийдвэрлэж байгаа шүүгч хамтатган шийдвэрлэнэ.

7.Нэхэмжлэлийн шаардлагаас нэг буюу хэд хэдэн шаардлагыг тусгаарласан тохиолдолд тухайн захирамж гаргасан шүүгч өөрөө тусгаарласан хэргийг хянан шийдвэрлэнэ.

8.Согтуурах, мансуурах донтой этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэхээр Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг шуурхай шийдвэрлэх онцлогийг харгалзан хуваарилахдаа нэхэмжлэл хүлээн авах боломжтой, тухайн өдөр ажиллаж байгаа албан ёсны чөлөөтэйгөөс бусад шүүгчид тойрог дотор санамсаргүй аргаар хуваарилна.

9.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 170.1 дэх хэсэгт зааснаар гомдол гаргасан тохиолдолд уг хэргийг шийдвэрлэж байгаа шүүгчийг оролцуулахгүйгээр тус журмын 2.1 дэх заалтад заасан дарааллаар хуваарилна.

10. Шүүхийн шийдвэр албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг шийдвэрлэхэд захирамж, гүйцэтгэх хуудасны дугаарыг тухайн хэргээс нь авна.

Дөрөв. Эрүүгийн хэрэг хуваарилах

1. Шүүхэд ирсэн эрүүгийн хэрэг эрүүгийн хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем болон Цөм 2 системээс "тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчмаар доорх 4 аргаар хуваарилна.

а. Ердийн журмаар б, в, г-д зааснаас бусад бүх хэргийг хуваарилна.

б. "Ачаалал тэнцүүлж хэрэг хуваарилах арга"-аар яллагдагчийн тоо 3 болон түүнээс дээш эсвэл, 5 болон түүнээс дээш хавтаст хэргийг хуваарилна.

в. "Тодорхой төрлийн хэрэг хуваарилах арга"-аар шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэх хэргийг хуваарилна. (шүүх бүрэлдэхүүнтэй шийдвэрлэх хүнд ангиллын хэрэг)

г. ачаалал тэнцүүлэх арга ба тодорхой төрлийн хэрэг хуваарилах аргад заасан нөхцөлүүдийг давхар хангасан тохиолдолд ачаалал тэнцүүлэх аргаар хэргийг хуваарилна.

2. ажилтан хэрэг хуваарилах журамд зааснаар ямар хэргийг ердийн, ачаалал тэнцүүлэх, тодорхой төрлийн хэрэг хуваарилах аргаар нарийвчилсан журамд заасны дагуу нэгдсэн системд мэдээллээ хийхэд систем өөрөө хэргийг ердийн, ачаалал тэнцүүлэх, тодорхой төрлийн хэрэг хуваарилах аргуудын аль нэгээр тойрог дотор санамсаргүй сонгогдох зарчмаар хуваарилсныг мэдээлэл лавлагааны мэргэжилтэн шүүгчид хүлээлгэн өгнө.

3. Прокурорт буцаасан хэрэг буцаж ирвэл уг хэргийг буцаасан шүүгчид хуваарилах, уг буцаасан захирамж давж заалдах, хяналтын шатны шүүхээр хянагдаад хүчингүй болж буцаж ирвэл хэргийг буцаасан шүүгчид хуваарилах, хэргийг буцаасан шүүгч ээлжийн амралт болон бусад шалтгаанаар тохиолдолд ажиллаж байгаа шүүгчид хуваарилаад ээлжийн амралт дуусч ажилдаа орж ирэхэд буцааж өгнө.

4. анхан шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хэргийн шийдвэр давж заадах болон хяналтын шатны шүүхээс хүчингүй болж дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол хэргийг өмнө шийдвэрлэсэн шүүгчийг алгасаж, шүүгчид тойрог дотроос санамсаргүй байдлаар хуваарилах,

5. Давж заалдах, хяналтын шатны шүүхэд гомдол гаргах хугацаа сэргээлгэх хүсэлтийг тухайн хэргийг өмнө нь шийдвэрлэсэн шүүгчид өгөх, хэрэг шийдсэн шүүгч ээлжийн амралт, чөлөөтэй болон тухайн шүүхэд ажиллахгүй болсон тохиолдолд ерөнхий шүүгч, түүний эзгүйд орлож байгаа шүүгч шийдвэрлэнэ.

6. Шүүхийн шийдвэр биелүүлэхтэй холбоотой Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-12 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг сугалаагаар тогтоосон дарааллаар тойргоор хуваарилах,

Тав. Зөрчлийн хэрэг хуваарилах

1. Ажилтан прокурорын дүгнэлт, оролцогчийн гомдол, зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан болон Зөрчлийн тухай хуулийн 15.3, 15.4, 15.5 дугаар зүйлд заасан зөрчлийн хэргийг бүртгэж энэ журмын 2.1-д заасан дараалалаар дардас дарж баталгаажуулж хүлээн авна.

2. анхан шатны шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн зөрчлийн хэргийн шийдвэр давж заалдах шатны шүүхээс хүчингүй болж дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол хэргийг өмнө шийдвэрлэсэн шүүгчийг алгасаж, энэ журмын 2.1-д заасан дарааллаар шүүгчид хуваарилна.

3. зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар зөрчлийн хэргийг хэлэлцэх шүүх хуралдааныг завсарлуулж, хэрэг бүртгэлтийн нэмэлт ажиллагаа хийлгүүлэхээр цагдаагийн байгууллагад даалгасан хэрэг буцаж ирсэн тохиолдолд түүнийг анх хүлээн авсан шүүгч шийдвэрлэнэ.

4. шүүгч өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай болон бусад хүндэтгэн үзэх шалтгаантай үед шүүх хуралдааныг завсарлуулсан зөрчлийн хэрэг дахин ирсэн тохиолдолд дараагийн шүүгч нарт нарийвчилсан журмын 2.1-д заасан дарааллаар хуваарилна.

5. зөрчлийн хэргийг түдгэлзүүлсэн бол тухайн шүүгч өөрөө шийдвэрлэнэ.

6. Цагдаагийн байгууллагаас ирж байгаа албадан гүйцэтгүүлэх хүсэлтийг энэ журмын 2.1-д заасан дарааллаар хуваарилна.

Зургаа. Таслан сэргийлэх арга хэмжээний санал, хүсэлтийг хүлээн авах, хуваарилах

1. Сэжигтнийг баривчлах, яллагдагчийг тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацааг сунгах тухай прокурор, оролцогчийн санал, хүсэлт, албадан саатуулах хугацаа сунгуулах хүсэлтийг мэдээлэл лавлагааны мэргэжилтэн хүлээн авч Ерөнхий шүүгчээс бусад шүүгчид журмын 2.1-д заасан дарааллаар, дарааллын шүүгч ажиллахгүй тохиолдолд дараагийн дараалалд бичигдсэн шүүгчид хуваарилна.

2. шүүгч ээлжийн амралттай болон бусад шалтгааны улмаас тухайн шүүхэд Ерөнхий шүүгчээс өөр шүүгч, эсхүл ерөнхий шүүгчийг түр орлон гүйцэтгэж байгаа шүүгчээс өөр шүүгч ажиллаагүй тохиолдолд сэжигтнийг баривчлах, яллагдагчийг тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, хязгаарлалт тогтоох, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, өөрчлөх, хүчингүй болгох, хугацааг сунгах тухай прокурор, оролцогчийн санал, хүсэлт, албадан саатуулах хугацаа сунгуулах хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ. Уг шийдвэрт гомдол гаргасан тохиолдолд адил шатны өөр шүүхийн Ерөнхий шүүгч, ерөнхий шүүгчийг орлон ажиллаж байгаа шүүгчээр шилжүүлж шийдвэрлүүлнэ.

Долоо. Гомдол, хүсэлт, дүгнэлт хүлээн авах

1. тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой оролцогч болон талуудын гомдол хүсэлтийг хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчид, бусад гомдол, хүсэлтийг Ерөнхий шүүгчийн туслах систем болон бүртгэлд бүртгэж,

аргачлалын 3.1.4-т заасны дагуу дардас дарж баталгаажуулж шүүгч болон Ерөнхий шүүгчид даруй хүлээлгэн өгнө.

2.Шүүхийн шийдвэр биелүүлэх ажиллагаатай холбоотой гаргасан гомдол, хүсэлт, прокурорын дүгнэлтийг шийдвэр гаргасан шүүгч өөрөө шийдвэрлэнэ. Тухайн шүүхээс өөр шүүхийн шийдвэрт дээрх хүсэлт ирсэн тохиолдолд журмын 2.1-д заасан дарааллаар хуваарилна.

Найм. Бусад

1.Шүүгчид ээлжийн амралт эхлэхээс ажлын 7 хоногийн өмнө журмын 3, 4, 6 дах хэсэгт заасан хэрэг, өргөдөл гомдол, хүсэлтийг хуваарилалтыг зогсооно, ажлын 3 хоногийн өмнө 5-д заасан хэрэг, өргөдөл гомдол хүсэлт хуваарилалтыг зогсоох, ажилд орсон өдрөөс эхлэн хуваарилна.

2.Шүүгч ажлын 14 хоног болон түүнээс дээш хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгаан бий болсон тохиолдолд эрүүгийн хэрэг, иргэний хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол хүсэлт хуваарилахгүй бөгөөд иргэний хэргийн хувьд хэрэг шилжүүлэхгүй, эрүүгийн хэрэг, зөрчлийн хувьд бусад шүүгчид хэргийг хуваарилж, шүүгч ажилдаа орох үед үлдэгдэл хэргийг буцаан өгнө. Шүүгч 3 хоногоос дээш хугацаагаар чөлөө авсан тохиолдолд Зөрчлийн хэрэг, цагдан хорих саналыг хуваарилахгүй зогсооно.

3.Шүүгч шилжсэн, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тохиолдолд өмнө нь хуваарилагдсан үлдэгдэл иргэн, зөрчлийн хэргийг үлдсэн шүүгч нарт зөвлөгөөний тогтоолын 2.1-д заасан дарааллаар, эрүүгийн хэргийг программаас унагааж хуваарилна.

4.Шүүгч солигдсон тохиолдолд түүнд хуваарилагдсан үлдэгдэл эрүүгийн хэрэг, зөрчлийн хэрэг, гомдол, хүсэлт, прокурорт буцаасан хэргийг шинээр ирсэн шүүгчид шилжүүлнэ.

5.Энэхүү журмыг Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт зааснаар олон нийтэд нээлттэй, шүүхийн цахим хуудсанд байршуулна.

6.Хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилох программын ажиллагаа, программ дээр хийгдсэн үйлдэл бүрийг дүрс бичлэг хийх бөгөөд программд хандсан хэрэглэгчийн эрх, үйлдлийн дэлгэрэнгүй мэдээлэл, бүртгэл нь хадгалагдаж, тэдгээрт хөндлөнгийн хяналт хийгдэх боломжтой байна.

7.Энэхүү журмаар зохицуулаагүй асуудлыг тухай бүр шүүгч нарын зөвлөгөөнөөр шийдвэрлэнэ.